



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/238/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Аудитор: Ж.Бямбацогт
Утас: 261628 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит
ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа
Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	18
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Албан шаардлага:	25
5.2 Зөвлөмж:	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Э.АНХБАЯР ТАНАА

2026.02.25 № 06/452

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,900,497.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны эцэст 40 байгууллага, хувь хүмүүсийн 396,466.9 мянган төгрөгийн авлагын дансны үлдэгдэл, 81 харилцагчийн 5,596,965.7 мянган төгрөгийн өглөгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд байхгүй 171 удаагийн 2,242,501.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авч, гэрээг дүгнээгүй, нээлттэй тендер сонгон шалгаруулалт болон харьцуулалтын аргаас зайлсхийсэн;
- Өмнөх оноос дамжин хэрэгжсэн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 42 гэрээний үнийн дүнгээс 1,578,996.3 мянган төгрөгөөр илүү худалдан авсан, нийт 85 гэрээг дүгнэж акт үйлдээгүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн

болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31 дугаар зүйлийн 31.1.1, 31.1.2, 32 дугаар зүйлийн 32.1 гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэмжлэгийн хүрээнд “Эрхтэн шилжүүлэн суулгах төв” болон чихрийн шижин өвчнийг эмчлэх зорилгоор “Диабетийн төв”-ийг нээж, ашиглалтад оруулсан байна. Тус төвүүдийг ашиглалтад оруулахад Сангийн яам, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 6,964,485.7 мянган төгрөгийн барилгын их засвар, тусгай тоног төхөөрөмжтэй автомашин болон багаж техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 4,490,969.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг тус тус нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ТӨБЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 295 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 628 нэрийн, нийт 13,165,447.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 6,579,161.0 мянган төгрөгөөр балансын үнийг шинэчлэн тогтоож бүртгэсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар тус эмнэлгийн захирлыг 2025 оны 7 дугаар сард түр хугацаагаар томилсон, 2024 оноос ахлах нягтлан бодогчийг 4 удаа чөлөөлж, шинээр томилсон, мөн хяналт шинжилгээ, үнэлгээний, дотоод хяналтын ажилтан, худалдан авалтын мэргэжилтнүүд тайлант онд шинээр томилогдсон зэрэг албан тушаалтны тогтворгүй байдал нь үүрэг хариуцлагын тогтолцоо, дотоод хяналтын орчинд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Ц. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,645,077,266.30	17,290,763,642.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,392,480,992.26	202,368,647.14
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,388,720,332.26	199,117,647.14
31210	Төгрөг	2,388,720,332.26	199,117,647.14
31211	Төрийн сангийн харилцах	2,388,720,332.26	199,117,647.14
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.00	-
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	3,760,660.00	3,251,000.00
33	АВЛАГА	4,167,772,450.78	6,935,350,714.96
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,794,064.00	3,926,055.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,917,662,329.60	6,483,663,829.78
33500	Бусад авлага	241,316,057.18	447,760,830.18
33510	Байгууллагаас авах авлага	223,707,796.30	430,698,570.30
33520	Хувь хүмүүсээс авах авлага	17,608,260.88	17,062,259.88
34	УРЬДЧИЛГАА	3,444,336.00	115,565,459.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	113,150,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	3,444,336.00	2,415,459.00
34713	Цалингийн урьдчилгаа	3,444,336.00	2,415,459.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,081,379,487.26	10,037,478,821.73
35100	Түүхий эд материал	4,273,107,491.85	3,886,472,129.57
35110	Тусгай зориулалттай материал	21,489,156.50	47,099,913.86
35130	Эм боох материал	4,251,618,335.35	3,839,372,215.71
35400	Хангамжийн материал	5,808,271,995.41	6,151,006,692.16
35410	Бичиг хэргийн материал	31,313,340.37	12,283,667.02
35420	Аж ахуйн материал	279,980,444.67	180,480,795.60
35430	Сэлбэг хэрэгсэл	396,181,640.00	98,868,100.00
35440	Түлш, шатах тослох материал	4,958,352.07	3,223,032.35
35450	Барилгын засварын материал	19,533,940.00	59,799,467.39
35460	Хүнсний материал	33,830,365.30	27,400,126.95
35470	Бусад хангамжийн материал	5,042,473,913.00	5,768,951,502.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	94,801,072,797.05	100,731,230,581.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	94,801,072,797.05	100,731,230,581.29
39200	Биет хөрөнгө	93,054,431,279.15	98,805,662,687.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	62,460,189,162.05	62,719,597,613.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,363,636,472.44)	(6,183,971,265.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,488,961,484.80	3,289,991,484.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(385,495,662.91)	(605,724,910.11)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	85,934,370,532.31	90,305,575,027.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,373,100,882.16)	(53,355,185,404.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,289,789,378.74	4,044,585,198.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,391,942,320.74)	(1,672,675,677.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,178,427,630.00	1,189,247,630.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	101,992,094,348.78	67,034,711,443.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,506,151,729.28	67,034,711,443.78
120	Нийтлэг татварын бус орлого	65,506,151,729.28	26,446,547,712.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,676,543,442.22	19,144,509,592.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,471,580,003.52	5,406,992,959.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,204,963,438.70	13,737,516,633.69
120005	Түрээсийн орлого	178,146,000.00	-
120009	Бусад орлого	6,195,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	56,180,160,559.60	6,822,668,111.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	465,106,727.46	479,370,009.09
122	Тусламжийн орлого	-	40,588,163,731.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	40,588,163,731.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	40,588,163,731.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	40,588,163,731.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,485,942,619.50	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,485,942,619.50	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,485,942,619.50	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	64,640,265,620.96	68,495,617,961.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,640,265,620.96	68,495,617,961.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,245,206,076.96	67,985,500,702.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,929,587,197.00	23,525,894,147.75
210101	Үндсэн цалин	10,106,894,985.00	11,690,423,791.75
210102	Нэмэгдэл	7,222,186,368.00	8,865,519,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,221,394,000.00	1,315,961,746.00
210104	Урамшуулал	1,379,111,844.00	1,653,989,551.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,588,102,298.29	3,034,469,509.73
210201	Тэтгэврийн даатгалын зардал	2,203,371,855.29	2,581,582,505.49
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	384,730,443.00	452,887,004.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,644,627,821.00	1,967,204,130.15
210301	Гэрэл, цахилгаан	902,689,173.45	1,211,488,942.61
210302	Түлш, халаалт	305,351,293.57	280,773,064.67
210303	Цэвэр, бохир ус	436,587,353.98	474,942,122.87
2104	Хангамж, бараа материалын зардал	1,534,469,432.91	1,334,004,398.39
210401	Бичиг хэрэг	119,635,335.07	116,500,054.35
210402	Тээвэр, шатахуун	136,707,006.00	83,836,206.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,177,950.36	47,815,053.72

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	397,607,300.27	434,945,992.12
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	855,341,841.21	650,907,091.48
2105	Нормативт зардал	23,343,728,898.88	21,918,905,052.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,751,518,897.92	21,259,868,207.43
210502	Хоол, хүнс	439,856,737.46	487,009,638.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,353,263.50	172,027,206.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	389,786,685.00	1,299,362,639.58
210604	Урсгал засвар	389,786,685.00	1,299,362,639.58
2107	Томилолт, зочны зардал	404,201,020.00	45,180,000.00
210701	Гадаад албан томилолт	19,030,000.00	-
210702	Дотоод албан томилолт	385,171,020.00	45,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,093,535.65	274,098,520.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,297,903.65	184,916,433.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,614,500.00	15,385,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	979,020.00	902,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	854,848.00	4,828,336.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,148,052.00	63,148,652.00
210807	Газрын төлбөр	3,901,212.00	4,583,539.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	298,000.00	333,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,109,609,188.23	14,586,382,304.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,139,300.00	22,105,507.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	945,212,153.73	1,351,913,302.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,029,257,734.50	13,212,363,493.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	395,059,544.00	510,117,259.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	395,059,544.00	510,117,259.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	318,634,831.00	482,825,459.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	76,424,713.00	27,291,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,351,828,727.82	(1,460,906,517.76)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	186,260.30	29,801.43
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	186,260.30	29,801.43
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(186,260.30)	(29,801.43)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	37,351,642,467.52	(1,460,936,319.19)

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	46,104,573,509.13	49,917,095,897.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,291,483,721.18	49,917,095,897.84
120	Нийтлэг татварын бус орлого	9,291,483,721.18	11,894,933,667.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,291,483,721.18	11,894,933,667.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,818,312,012.72	5,147,045,213.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,473,171,708.46	6,747,888,454.02
122	Тусламжийн орлого	-	38,022,162,230.82
1221	Хандив тусламж /дотоод/	-	38,022,162,230.82
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	38,022,162,230.82
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	38,022,162,230.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,813,089,787.95	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,813,089,787.95	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,813,089,787.95	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,647,312,351.99	52,107,208,242.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,647,312,351.99	52,107,208,242.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,252,016,807.99	51,598,957,983.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,767,309,190.00	22,776,439,049.85
210101	Үндсэн цалин	11,443,540,764.00	11,164,521,900.85
210102	Нэмэгдэл	7,046,840,844.00	8,682,765,541.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,198,141,951.00	1,287,329,251.00
210104	Урамшуулал	1,078,785,631.00	1,641,822,357.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,691,082,193.19	2,426,136,800.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,892,402,186.49	1,661,164,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	373,479,084.15	191,243,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	83,761,155.23	95,621,600.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	70,803,965.83	95,621,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	270,635,801.49	382,486,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,629,966,700.73	1,875,314,520.27
210301	Гэрэл, цахилгаан	917,280,624.45	1,120,146,118.24
210302	Түлш, халаалт	276,653,597.71	283,887,940.17
210303	Цэвэр, бохир ус	436,032,478.57	471,280,461.86
2104	Хангамж, бараа материалын зардал	587,094,060.36	473,690,393.50
210401	Бичиг хэрэг	92,227,510.00	82,904,608.50
210402	Тээвэр, шатахуун	80,617,300.00	79,999,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,544,346.36	30,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	297,599,354.00	223,616,181.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	99,105,550.00	57,170,004.00
2105	Нормативт зардал	15,611,857,482.06	18,376,649,292.95

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,925,243,813.06	17,446,765,572.47
210502	Хоол, хүнс	614,433,757.00	736,854,251.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	72,179,912.00	193,029,469.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,029,958,490.00	5,321,618,323.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	295,229,881.00	4,957,385,794.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	955,000.00	-
210604	Урсгал засвар	733,773,609.00	364,232,529.00
2107	Томилолт, зочны зардал	409,877,420.00	54,180,000.00
210702	Дотоод албан томилолт	409,877,420.00	54,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	341,985,242.65	223,598,401.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	276,891,262.65	121,519,346.31
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,614,500.00	15,385,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	979,020.00	902,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	854,848.00	4,509,336.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	209,000.00	319,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,246,700.00	73,692,000.00
210807	Газрын төлбөр	3,901,212.00	4,583,539.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	279,800.00	329,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,008,900.00	2,358,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,886,029.00	71,331,203.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,886,029.00	17,973,101.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	53,358,101.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	395,295,544.00	508,250,259.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	395,295,544.00	508,250,259.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	22,356,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	318,634,831.00	482,825,459.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,660,713.00	3,068,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,457,261,157.14	(2,190,112,345.12)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	126,252,450.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	126,252,450.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	126,252,450.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	126,252,450.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(126,252,450.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,331,008,707.14	(2,190,112,345.12)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,472,285.12	2,392,480,992.26
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,392,480,992.26	202,368,647.14

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	41,035,142,345.60	57,948,219,654.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(7,855,650.00)	(7,855,650.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	41,027,286,695.60	57,940,364,004.58
Тайлант үеийн үр дүн			37,351,642,467.52	37,351,642,467.52
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	78,378,929,163.12	95,292,006,472.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7,368,265.17	7,368,265.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	78,386,297,428.29	95,299,374,737.27
Тайлант үеийн үр дүн			(1,460,936,319.19)	(1,460,936,319.19)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	76,925,361,109.10	93,838,438,418.08

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	54,436,558,000.00	49,917,600,557.84	4,518,957,442.16	91.7
12	Татварын бус орлого	54,436,558,000.00	49,917,600,557.84	4,518,957,442.16	91.7
120	Нийтлэг татварын бус орлого	14,624,805,700.00	11,895,438,327.02	2,729,367,372.98	81.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	5,693,267,200.00	5,147,045,213.00	546,221,987.00	90.4
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	8,931,538,500.00	6,748,393,114.02	2,183,145,385.98	75.6
122	Тусламжийн орлого	39,811,752,300.00	38,022,162,230.82	1,789,590,069.18	95.5
122001	Хандив тусламж /дотоод/	39,811,752,300.00	38,022,162,230.82	1,789,590,069.18	95.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,825,268,400.00	52,107,193,242.96	4,718,075,157.04	91.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,825,268,400.00	52,107,193,242.96	4,718,075,157.04	91.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,171,320,700.00	51,598,942,983.96	4,572,377,716.04	91.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,100,329,600.00	22,776,439,049.85	1,323,890,550.15	94.5
210101	Үндсэн цалин	12,654,530,200.00	11,164,521,900.85	1,490,008,299.15	88.2
210102	Нэмэгдэл	6,644,455,100.00	8,682,765,541.00	(2,038,310,441.00)	130.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,122,128,900.00	1,287,329,251.00	1,834,799,649.00	41.2
210104	Урамшуулал	1,679,215,400.00	1,641,822,357.00	37,393,043.00	97.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,426,167,100.00	2,426,136,800.00	30,300.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	1,661,194,400.00	1,661,164,100.00	30,300.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	191,243,200.00	191,243,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	95,621,600.00	95,621,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	95,621,600.00	95,621,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	382,486,300.00	382,486,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,875,653,400.00	1,875,314,520.27	338,879.73	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,040,653,400.00	1,120,146,118.24	(79,492,718.24)	107.6
210302	Түлш, халаалт	355,000,000.00	283,887,940.17	71,112,059.83	80.0
210303	Цэвэр, бохир ус	480,000,000.00	471,280,461.86	8,719,538.14	98.2
2104	Хангамж, бараа материалын зардал	507,912,700.00	473,690,393.50	34,222,306.50	93.3
210401	Бичиг хэрэг	103,000,000.00	82,904,608.50	20,095,391.50	80.5
210402	Тээвэр, шатахуун	80,000,000.00	79,999,600.00	400.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,912,700.00	223,616,181.00	(8,703,481.00)	104.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000,000.00	57,170,004.00	22,829,996.00	71.5
2105	Нормативт зардал	19,531,356,000.00	18,376,649,292.95	1,154,706,707.05	94.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,512,599,600.00	17,446,765,572.47	1,065,834,027.53	94.2
210502	Хоол, хүнс	822,424,500.00	736,854,251.00	85,570,249.00	89.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	196,331,900.00	193,029,469.48	3,302,430.52	98.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,199,645,300.00	5,321,618,323.00	1,878,026,977.00	73.9

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	6,757,148,000.00	4,957,385,794.00	1,799,762,206.00	73.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000,000.00	-	20,000,000.00	-
210604	Урсгал засвар	422,497,300.00	364,232,529.00	58,264,771.00	86.2
2107	Томилолт, зочны зардал	106,300,000.00	54,180,000.00	52,120,000.00	51.0
210702	Дотоод албан томилолт	106,300,000.00	54,180,000.00	52,120,000.00	51.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,756,600.00	223,583,401.31	122,173,198.69	64.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,000,000.00	121,519,346.31	110,480,653.69	52.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,614,500.00	15,385,500.00	229,000.00	98.5
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,100.00	902,160.00	97,940.00	90.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,100,000.00	4,509,336.00	1,590,664.00	73.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,000.00	319,000.00	31,000.00	91.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	73,692,000.00	73,692,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	6,000,000.00	4,583,539.00	1,416,461.00	76.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000.00	314,300.00	685,700.00	31.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000,000.00	2,358,220.00	7,641,780.00	23.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,200,000.00	71,331,203.08	6,868,796.92	91.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,200,000.00	17,973,101.90	5,226,898.10	77.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,000,000.00	53,358,101.18	1,641,898.82	97.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	653,947,700.00	508,250,259.00	145,697,441.00	77.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	653,947,700.00	508,250,259.00	145,697,441.00	77.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	22,356,600.00	7,643,400.00	74.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	575,947,700.00	482,825,459.00	93,122,241.00	83.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,000,000.00	3,068,200.00	44,931,800.00	6.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(2,388,710,400.00)	(2,189,592,685.12)	(199,117,714.88)	91.7
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,388,710,400.00	2,189,592,685.12	199,117,714.88	91.7
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,388,710,400.00	2,189,592,685.12	99,117,714.88	91.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,388,710,332.26		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	199,117,647.14		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,157.00	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	-	-	
610001	Төсвийн байгууллага	1	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	578	-	-	
620001	Удирдах ажилтан	1	-	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	421	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	156	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд улсын хэмжээнд Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үүргийг хэрэгжүүлэн, бүх төрлийн багажийн ба лабораторийн оношилгоо шинжилгээ, эмийн, мэс заслын, цөмийн, сэргээн засах, уламжлалт эмчилгээний өдрийн ба хэвтүүлэх тусламж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгийн төв зэрэг цогц үйлчилгээг иргэдэд хүргэдэг.

Мөн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг, Баянзүрх, Налайх, Багануур, Багахангай дүүргийн иргэдэд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Тус эмнэлэг нь орчин үеийн шинэ дэвшилтэт технологиудыг эх орондоо нэвтрүүлж, үйлчлүүлэгчдэд ээлтэй оношилгоо, эмчилгээг саадгүй хүргэхээс гадна нотолгоонд суурилсан анагаах ухааны ололт амжилтыг байнга эрэлхийлж, эрдэм шинжилгээ, судалгааны томоохон төв болох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд эмнэлгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”;
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”;
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 9/5792 дугаар албан бичгээр шалгалтын дүнг ирүүлсэн. Шалгалтаар хугацаа хоцроосон 3, мэдээлээгүй 16, хавсралт файл байршуулаагүй, тушаал шийдвэр дутуу байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш ажил гүйлгээнүүдийн мэдээллийг дутуу байршуулсан зөрчлүүд гарсныг дурдаж, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор нөхөн бүртгэх зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эмнэлгийн захирлын 2019 оны А/98 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын шинэчлэл өөрчлөлт, гүйцэтгэлээр санхүүжихтэй холбоотой орлого хүлээн зөвшөөрөлт, эмнэлгийн тусламж үйлчилгээний даатгалын санхүүжилтийн нэхэмжлэх, эм, тарианы ашиглах хугацаа, техникийн үзүүлэлтүүдийг эмчилгээ үйлчилгээний анхан шатны үйл ажиллагааны болон санхүү нягтлан бодох бүртгэлийн програмтай уялдуулаагүй зэрэг байгууллагын онцлог бүртгэлүүдийг тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,575,844.1 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,392,481.0	202,368.6	(2,190,112.4)
Авлага	4,167,772.4	6,935,350.7	2,767,578.3
Урьдчилж гарсан зардал	3,444.3	115,565.5	112,121.1
Бараа материал	10,081,379.5	10,037,478.8	(43,900.7)
Үндсэн хөрөнгө	94,801,072.9	100,731,230.5	5,930,157.6
Биет бус хөрөнгө	1,746,641.5	1,925,567.9	178,926.3
Нийт хөрөнгө	111,446,150.0	118,021,994.2	6,575,844.1
Богино хугацаат өр төлбөр	16,154,143.6	24,183,555.8	8,029,412.3
Засгийн газрын хувь оролцоо	11,941,287.1	11,941,287.1	-
Хуримтлагдсан үр дүн	78,378,929.2	76,925,361.1	(1,453,568.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,971,790.2	4,971,790.2	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	111,446,150.0	118,021,994.2	6,575,844.2

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данстууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 202,368.6 мянган төгрөг болж, 2,190,112.4 мянган төгрөгөөр буурсан нь гэрээний дагуу урьдчилгаа төлбөрүүд хийгдэж, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт бүрэн орж ирээгүйтэй холбоотой;

Авлагын дансны үлдэгдэл 6,935,350.7 мянган төгрөг болж, 2,767,578.3 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-ийн санхүүжилт 6,483,663.8 мянган төгрөг төлөгдөөгүй нь голчлон нөлөөлсөн;

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 100,731,230.5 мянган төгрөг болж 5,930,157.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 4,195,567.2 мянган төгрөг, хандив, тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 6,822,668.1 мянган төгрөг, бусад байгууллагаас шилжин ирсэн хөрөнгө 1,623,689.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 234 дүгээр тогтоолоор 266,861.4 мянган төгрөг, 304 дүгээр тогтоолоор 368,980.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталж данснаас хассан, 295 дугаар тогтоолоор үнийг шинэчлэн тогтоосон хөрөнгийн үнийн зөрүү 6,604,377.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн;

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 24,183,555.8 мянган төгрөг болж 8,029,412.2 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь бараа үйлчилгээний зардлын өглөг 3,41,556.1 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 3,334,495.0 мянган төгрөг, суутган татварын өглөг 1,650,570.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,004,967.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн;

Цэвэр хөрөнгө өмчийн дүн хуримтлагдсан үр дүн 1,453,568.1 мянган төгрөгөөр буурсан.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Эмералд санхүүгийн программ ашигладаг. Төсвийн байгууллагын үйл ажиллагаанд тохирсон боловч ерөнхий журнал, үндсэн хөрөнгийн журналын гүйлгээг тайлангийн тодруулгыг зөрүүтэй мэдээлсэн, хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой өөрчлөлтийг хийгдээгүй байгаа тул программын шинэчлэл, өөрчлөлтийг хийлгэж, өргөтгөсөн хувилбарыг ашиглах шаардлагатай байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эмнэлгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 34,423,918.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 15,397,015.3 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 49,820,934.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналыг хэвээр баталж, дээд шатны захирагчаас 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын сангаас 41,166,688.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,015,023.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,250,511.9 мянган төгрөг, урд оны үлдэгдлээс 2,388,710.4 мянган төгрөг, нийт 49,820,934.1 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Тайлант оны эцэст төсвийг тодотгож ЭМДС-ийн санхүүжилтийг 1,354,936.5 мянган төгрөгөөр бууруулж, үйл ажиллагааны орлогыг 5,970,560.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орлогыг 54,436,558.0 мянган төгрөгөөр баталсан.

Нийт зардлаас цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4,610,953.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,393,381.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 56,825,268.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 38,022,162.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 11,895,438.3 мянган төгрөг, нийт 49,917,600.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 91.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 52,107,193.2 мянган төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь олон улсын байгууллагаас олгосон 332,178.2 мянган төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс зарцуулж, үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,557,097.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан төсвийг 2,493,156.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөр	56,825,268.4	52,107,193.2	4,718,075.2	91.8
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	43,294,968.2	40,801,109.0	2,493,859.2	94.2
1.2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	78,000.0	25,424.8	52,575.2	32.6
1.3	81639- Төр хариуцах эмийн зардал	747,976.3	737,313.4	10,662.9	98.6
1.4	83601-Олон улсын байгууллагаас олгосон санхүүжилтийн зардал	-	332,178.2	(332,178.2)	-

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.5	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан санхүүжилт	8,213,354.1	5,720,198.0	2,493,156.1	69.7
1.6	83604-Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,490,969.8	4,490,969.8	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар:

Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу тус эмнэлэг нь тайлант онд Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн тусгайлан 9 хувийн цомхотгол хийгээгүй, тушаал бусад нотлох баримт ирүүлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн;

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Төвийн захирлын 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн А/76 дугаар тушаалаар ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 2,000.00 төгрөг, хоолны нэмэгдлийг 8,000.00 төгрөгөөр тооцож олгохоор баталсныг мөрдсөн. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлт 3,109,528.9 мянган төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,287,084.1 мянган төгрөг зарцуулсан;

3. Гадаад томилолт, арга хэмжээний үр дүнгийн талаар:

Гадаад томилолтын зардал гараагүй, дотоод албан томилолт 45,180.0 мянган төгрөгийн зардал гарч 62.8 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан;

4. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын талаар:

Өмнөх оны аудитаар удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан 2 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу цалин, НДШ-ийн нөхөн олговорт 15,637.5 мянган төгрөгийг төсвөөс олгосон, Шүүхийн шийдвэрийн дагуу харилцагч байгууллагад 61,333.2 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч буцааж авахаар авлагын тооцоо үүсгэсэн, нийт 76,970.7 мянган гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ аваагүй. Хариуцах эзэн ажлаас чөлөөлөгдсөн тул дээд шатны төсөв захирагчид шилжүүлсэн;


5. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Төвийн эмч мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөний хүрээнд тайлант онд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 55,000.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 53,358.1 мянган төгрөг зарцуулсан;

6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний талаар:

Энх-Арслан ХХК-тай хэвлэл мэдээлэл, мониторинг үйлчилгээний 9,900.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2025 оны эхний 3 улиралд үйлчилгээ авсан. Маркетингийн ажилтан 2025 оны 10 сард ажилд томилогдсон тул гэрээг дуусгавар болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	НТШ	20	18,820,525.2	20	15,852,345.0	84.2	-	2,967,907.1
2	ХА	5	358,133.2	2	153,417.7	42.8	3	204,715.5
3	ШХА	4	76,500.0	2	64,418.5	84.2	2	12,081.5
4	ГШБ	2	1,829,937.7	2	1,670,811.9	91.3	-	159,125.7
5	Нэг их үүсвэрт	5	4,067,367.5	2	2,622,824.6	64.5	3	1,444,542.8
6	ШХА		-	171	2,242,501.4	-	-	(2,242,501.4)
7	Эрх шилжиж ирсэн		-	1	4,490,969.7	-	-	(4,490,969.7)
Дүн		36	25,152,190.6	200	27,097,289.0	107.7	8	(1,945,098.4)

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 6 удаа өөрчлөлт оруулж 25,152,190.6 мянган төгрөгийн төлөвлөгөөг батлуулсан. Эрх шилжиж ирсэн болон төлөвлөгөөгүй шууд худалдан авалт хийснээс шалтгаалан төлөвлөгөөний гүйцэтгэл 107.7 хувьтай байна.

Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаас зайлсхийж, хэсэгчлэн хувааж 171 гэрээ байгуулан 2,242,501.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн эмнэлэг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эм, тарианы нөөцийг зохистой бүрдүүлж, дуусах хугацааг бүртгэж хянах, ажил гүйлгээний нотлох баримтыг бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнд тавигдах мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, эмнэлгийн батлагдсан бүтэц орон тоог баримтлан ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Ө.Ундармаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/096 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тайлант оны батлагдсан төсвийн дүн 49,820,934.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар бууу 498,209.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлсийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 болон 15 дугаар зүйлийн 15.1.1 - 15.1.8 дахь заалтуудад заасан хуулиар хориглох зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 11,450,409.2 мянган төгрөгийн зөрчлөөс 9,945,483.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 1,504,925.3 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт гэсэн 16 мэдээг хугацаа хоцроож, хандив тусламжийн орлого 7,302,038.1 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2,643,445.8 мянган төгрөгийн 52 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт:

Тус эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 онд батлагдаж, 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ч УСНББОУС, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй, бодлогын баримт бичиг нь санхүүгийн ажилтнуудад гарын авлага зааварчилга байх шаардлагыг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Газрын ашиглалт, улсын эрхийн бүртгэлийн хэрэгжилт:

Э-2204004012 эрхийн улсын дугаартай, 1,504,925.3 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 000439198 бүртгэлийн дугаартай газрын гэрчилгээний талбайн хэмжээ 46,477м² бөгөөд сунгалт хийгдсэн 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 0000265958 бүртгэлийн дугаартай гэрчилгээнд газрын хэмжээг 46,443 м² гэж 34 м²-аар дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Харьяа газрын албанд хүсэлт гаргаж, газрын гэрчилгээний зөрүүтэй бүртгэлийг арилгаж шийдвэрлүүлэх

3. Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоог баримтлах:

Ерөнхий захирлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/74 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоог 629 ажилтнаар баталсан, тайлант онд 9 хувийн цомхотгол хийгээгүй, тушаал шийдвэр гараагүй бөгөөд цалингийн хүснэгтээр нийт ажиллагсдын сарын дундаж 619 албан хаагч байгаа боловч шалгаагдагч байгууллагын ирүүлсэн цалингийн судалгаанд баталсан орон тоо 566 албан хаагч, гүйцэтгэлээр ажиллаж байгаа 615 албан хаагч, бууруулсан 61 албан хаагч гэж ирүүлсэн нь зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Орон тоо бүтцийг баталсан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах, судалгаа тооцоог үнэн зөв гаргаж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, байгууллагын газрын бүртгэл, батлагдсан орон тооны үзүүлэлт нь холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгаагдагч байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлсэн 594,096.9 мянган төгрөгийн 8 зөрчлийг шалгаагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, 8 зөвлөмж өгсөн. Жилийн эцсийн аудитаар дахин шалгахад 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, хэрэгжүүлээгүй 5 зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэн танилцуулж, 3 албан шаардлага, 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,754,603.6 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 657,425.9 мянган төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилт 62.2 хувь байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	9	1,754,603.6	4	1,265,262.1	44.4
2	Зөвлөмж	10	657,425.9	8	657,380.7	80.0
Нийт дүн		19	2,412,029.5	12	1,922,642.9	62.2

Хэрэгжилт хангалтгүй 5 албан шаардлага, 2 зөвлөмжид дараагийн шатны шийдэл, 1 зөвлөмжийг дээд шатны төсөв захирагчид шилжүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн шатны төсөв захирагчийн анхаарал хандуулах шаардлагатай дараах асуудал байна. Үүнд:

1. 2023 оны аудитаар тус эмнэлгийн ТУЗ байгуулагдаагүйгээс эмнэлгийн гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулагдаагүй зөрчилд зөвлөмж, 2024 оны аудитаар өмнөх зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага тус тус хүргүүлсэн байна. 2025 онд дээрх албан шаардлага мөн хэрэгжээгүй. ЭМЯ-аас эмнэлгийн ТУЗ-г зохион байгуулж томилоогүй байна.

Бид эмчилгээ үйлчилгээний анхан шатны бүртгэл E-Health болон санхүүгийн программаар бүртгэлийн уялдаа холбоо, нормативд зардлуудад орц норм баримталсан эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан шалгана. Үүнд:

1. Лабораториудын шинжилгээний бодис урвалжуудын зардлыг орц нормд үндэслэн, шинжилгээний тоо, орлоготой уялдуулдаг эсэх;
2. Хоол хүнсний зардлыг хэвтэн эмчлүүлэгсдийн тоо, хоолны цэс үндэслэн орц нормыг хянадаг эсэх;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,503,320.9 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдал, үр дүнгийн тайлангуудын тодруулга баганыг тодруулаагүй, тодруулга 2 дутуу байгаа нь санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй байна;
- Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр тайлагнаагүй мөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсөвтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, биелээгүй шалтгааныг тайлбарлаж тодруулаагүй зэрэг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна;
- Санхүүгийн байдлын тайлан, тодруулгаас Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл нийт 1,503,320.9 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 12,900,497.3 мянган төгрөгийн 7 зөрчил илэрсэнд 9,565,545.0 мянган төгрөгийн 3 хариуцлага тооцох албан шаардлага, 3,101,101.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 233,850.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,900,497.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон 498,209.3 мянган төгрөгийн материаллаг байдлаас давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага:

1. Тус эмнэлгийн эрүүл мэндийн даатгалын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 2,543,145.7 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх”, 13.1.2-т “эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах”, 13.1.4-д “даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх”, 13.1-д “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас

нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, ЭМДС-ийн эмчийн хяналтаар хасагддаг зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй 6,964,485.7 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, үндсэн хөрөнгийг нийлүүлснээс 6,554,570.4 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг Эрүүл мэндийн сайд болон төрийн нарийн бичгийн даргын тушаалаар хуваарилсан, 409,915.3 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хуваарилсан тушаал, шийдвэргүй байна. Мөн Эрүүл мэндийн яамтай жилийн эцэст 6,816,444.9 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нь хүлээн авсан хөрөнгөөс 148,040.9 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүй бараа материал хуваарилсан, жилийн эцэст зөрүүтэй тооцоо нийлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

3. Тайлант оны эцэст авлагын дансанд 40 байгууллага, хувь хүмүүсийн 396,466.9 мянган төгрөг, өглөг дансны үлдэгдэлд 81 харилцагчийн 5,347,580.4 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд байхгүй 171 удаагийн 2,242,501.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн шууд худалдан авалт хийж, гэрээг дүгнээгүй, үүнээс 4 байгууллагатай тендер зарлалгүй нэг өдөр 488,525.8 мянган төгрөгийн 2-6 удаагийн гэрээг шууд байгуулж нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Мөн өмнөх оноос дамжин хэрэгжсэн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 42 гэрээний үнийн дүнгээс 1,578,996.3 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийсэн, 2024-2025 онуудын эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 85 гэрээг

дүгнэж акт үйлдээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжилт хангалтгүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу явуулаагүй, худалдан авах гэрээний хэрэгжилтийг бүртгэж, гүйцэтгэлийг хянаагүй, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5. Өмнөх оны аудитаар удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан 2 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу цалин, НДШ-ийн нөхөн олговорт, нийт 15,637.5 мянган төгрөгийг төсвөөс олгосон. Шүүхийн шийдвэрийн дагуу харилцагч байгууллагад 61,333.2 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч буцааж авахаар авлагын тооцоо үүсгэсэн, гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ, 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", 103.4 "Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой:

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын журналын ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 13 байгууллага, хувь хүний 38,253.0 мянган төгрөгийн гүйлгээ цахим баримтаар баталгаажуагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг бүртгэхдээ анхан шатны баримтын үнэн зөв, иж бүрэн байдлыг хангаж ажиллах

2. Бараа материалын данстай холбоотой:

Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийн дансанд он дамжсан, тайлант онд зарцуулалт гараагүй 1,650 нэрийн 195,597.4 мянган төгрөгийн эм, тарианы үлдэгдэлтэй байна. Энэ нь эмийн бүртгэлийг Карте программ болон санхүүгийн программ нь уялдаа хамааралгүй, эмийн орлого авах болон ашиглалтын хугацааг бүртгээгүй, оруулсан мэдээллийг боловсруулж сар улирлын мэдээ тайланг гарахгүй байгаагаас эмийн бүртгэл ашиглалтад тавих хяналт хангалгүй, цаашид хэрэгцээ шаардлагагүй эмийн нөөц үүсгэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Программын байгууллагад хандаж орлогод авч байгаа эмийн техникийн нөхцөл, дуусах хугацаа зэрэг мэдээллүүдийг бүртгэх, оруулсан мэдээллүүдийг боловсруулж шаардлагатай мэдээ тайлангуудыг тухай бүр, сар, улирал жилээр тайлагнахаар өөрчлөлт сайжруулалт хийх.

Дээрх албан шаардлага болон зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн байдал, үр дүнгийн тайлангуудын тодруулга баганыг тодруулаагүй, тодруулга 2 дутуу байгаа нь санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй байна.	1	-	1	-			1	-				
2	Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр тайлагнаагүй мөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсөвтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, биелээгүй шалтгааныг тайлбарлаж тодруулаагүй зэрэг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна	1	-	1	-			1	-				
3	Санхүүгийн байдлын тайлан, тодруулгаас Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл нийт 1,503,320.9 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн байна.	1	1,503,320.9	1	1,503,320.9			1	1,503,320.9				
Дүн		3	1,503,320.9	3	1,503,320.9	-	-	3	1,503,320.9	-	-	-	-

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус төвийн эрүүл мэндийн даатгалын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 2,543,145.7 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.	1	2,543,145.7			1	2,543,145.7						
2	Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй 6,964,485.7 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, үндсэн хөрөнгийг нийлүүлснээс 6,554,570.4 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг Эрүүл мэндийн сайд болон төрийн нарийн бичгийн даргын тушаалаар хуваарилсан, 409,915.3 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хуваарилсан тушаал шийдвэргүй байна. Мөн Эрүүл мэндийн яамтай жилийн эцэст 6,816,444.8 мянган төгрөгөөр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нь хүлээн авсан хөрөнгөөс 148,040.8 мянган төгрөгөөр дутуу байна.	1	557,956.2			1	557,956.2						
3	Мөнгөн хөрөнгийн зарлагын журналын ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 13 байгууллага, хувь хүний 38,253.0 мянган төгрөгийн гүйлгээ цахим баримтаар баталгаажуулаагүй.	1	38,253.0					1	38,253.0				
4	Тайлант оны эцэст авлагын дансанд 40 байгууллага, хувь хүмүүсийн 396,466.9 мянган төгрөг, өглөг дансны үлдэгдэлд 81 харилцагчийн 5,347,616.4 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	5,744,047.3							1	5,744,047.3		

**Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5	Эм, эмнэлгийн хэрэгсэлийн дансанд он дамжсан, тайланд онд зарцуулалт гараагүй 1,650 нэрийн 195,597.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь эмийн бүртгэлийг Карте программ болон санхүүгийн програм нь уялдаа хамааралгүй, эмийн орлого авах болон ашиглалтын хугацааг бүртгэдгүй, оруулсан мэдээллийг боловсруулж сар улирлын мэдээ тайланг гарахгүй байгаагаас эмийн бүртгэл ашиглалтад тавих хяналт хангалгүй, цаашид хэрэгцээ шаардлагагүй эмийн нөөц үүсгэх эрсдэлтэй байна	1	195,597.4					1	195,597.4				
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд байхгүй 171 удаагийн 2,242,501.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн шууд худалдан авалт хийж, гэрээг дүгнээгүй, 4 байгууллагатай тендер зарлалгүй нэг өдөр 488,525.8 мянган төгрөгийн 2-6 удаагийн гэрээг шууд байгуулж нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Өмнөх оноос дамжин хэрэгжсэн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 42 гэрээний үнийн дүнгээс 1,578,996.3 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийсэн.	1	3,821,497.7							1	3,821,497.7		
7	Өмнөх оны аудитаар удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан 2 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговорт, нийт 15,637.5 мянган төгрөгийг төсвөөс олгосон, Шүүхийн шийдвэрийн дагуу харилцагч байгууллагад 61,333.2 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч буцааж авахаар авлагын тооцоо үүсгэсэн, гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна.	1	-							1	-		
Дүн		7	12,900,497.3	-	-	2	3,101,101.9	2	233,850.4	3	9,565,545.0	-	-

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Зөвлөмж		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт гэсэн 16 мэдээг хугацаа хоцроож, хандив тусламжийн орлогын 7,302,038.1 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2,643,445.8 мянган төгрөгийн 52 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	9,945,483.9			1	9,945,483.9		
Дүн		1	9,945,483.9	-	-	1	9,945,483.9	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	УХТЭ-ийн Захирлын 2024.04.12-ны өдрийн А/74 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоог 629 ажилтнаар баталсан тушаалаар бүтцийг шинэчлэн батлахдаа 9 хувийн цомхотгол хийгээгүй. Тайлант онд цомтголтой холбоотой тушаал шийдвэр гараагүй. орон тоог дотооддоо шилжүүлж Цалингийн хүснэгтээрх нийт ажиллагсдын сарын дундаж 619 хүн байна. Шалгагдагч байгууллагын ирүүлсэн цалингийн судалгаанд баталсан 566 албан хаагч, гүйцэтгэлээр 615, бууруулсан 61 гэж ирүүлсэн нь зөрүүтэй байна.	1	-	1	-				
2	Тус эмнэлгийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 онд батлагдаж, 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ч УСНББОУС, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй, бодлогын баримт бичиг нь санхүүгийн ажилтнуудад гарын авлага зааварчилга байх шаардлагыг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-		
3	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй Э-2204004012 эрхийн улсын бүртгэлийн дугаартай, 000439198 бүртгэлийн дугаартай 2017.07.31-ний газрын гэрчилгээний хэмжээ 46,477м2, асуудлын бүртгэл танилцуулсны дараа ирсэн 0000265958 бүртгэлийн дугаартай 2024.10.18-ний газрын гэрчилгээний хэмжээ 46,443 м2 болж сунгалт хийлгэхдээ хэмжээ 34 м2-р багасч өөрчлөгдсөн байна.	1	1,504,925.3	1	1,504,925.3				
Дүн		3	1,504,925.3	2	1,504,925.3	1	-	-	-
НИЙТ ДҮН		4	11,450,409.2	2	1,504,925.3	2	9,945,483.9	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 480/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026 /238/НА -СТА -ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт гэсэн 16 мэдээг хугацаа хоцроож, хандив тусламжийн орлогын 7,302,038,120.00 /долоон тэрбум гурван зуун хоёр сая гучин найман мянга нэг зуун хорин/ төгрөг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2,643,445,838.00 /хоёр тэрбум зургаан зуун дөчин гурван сая дөрвөн зуун дөчин таван мянга найман зуун гучин найман/ төгрөгийн 52 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Ерөнхий захирал /Э.Анхбаяр/, Санхүү албаны дарга /М.Солонго/ Ерөнхий нягтлан бодогч /Ж.Нарантунгалаг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-92.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 481 /А015 0185

Улаанбаатар хот

САГ-2026/238/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн эрүүл мэндийн даатгалын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 2,543,145,724.00 /хоёр тэрбум таван зуун дөчин гурван сая нэг зуун дөчин таван мянга долоон зуун хорин дөрвөн/ төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг 30.0 хүртэл хувиар бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Ерөнхий захирал /Э.Анхбаяр/, Санхүү албаны дарга /М.Солонго/, Эмнэл зүй зохицуулах албаны дарга /О.Марал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-92.Docx

1526181063



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 482/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/238/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй 6,964,485,721.00 /зургаан тэрбум есөн зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун наян таван мянга долоон зуун хорин нэгэн/ төгрөгийн багаж хэрэгсэл, үндсэн хөрөнгийг нийлүүлснээс 6,554,570,410.00 /зургаан тэрбум таван зуун тавин дөрвөн сая таван зуун далан мянга дөрвөн зуун арван/ төгрөгийн хөрөнгө, бараа материалыг Эрүүл мэндийн сайд болон төрийн нарийн бичгийн даргын тушаалаар хуваарилсан, 409,915,311.00 /дөрвөн зуун есөн сая есөн зуун арван таван мянга гурван зуун арван нэгэн/ төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хуваарилсан тушаал шийдвэргүй байна. Мөн Эрүүл мэндийн яамтай жилийн эцэст 6,816,444,861.00 /зургаан тэрбум найман зуун арван зургаан сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун жаран нэгэн/ төгрөгөөр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нь хүлээн авсан хөрөнгөөс 148,040,860.00 /нэг зуун дөчин найман сая дөчин мянга найман зуун жаран/ төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, бараа материалын тушаал, шийдвэр дутуу, тооцоо нийлсэн акт дутуу зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Э.Анхбаяр/, санхүү албаны дарга /М.Солонго/ ахлах нягтлан бодогч /Ж.Нарантунгалаг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-92.Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БА 1526181065
ХЛЭГ ААРЛАЛТАН
САНАЛ ДҮТЭЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 483/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/238/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 онд батлагдаж, 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ч УСНББОУС, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй, бодлогын баримт бичиг нь санхүүгийн ажилтнуудад гарын авлага зааварчилга байх шаардлагыг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахгаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг бүрэн тусгаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвөөс хөрөнгө зарцуулахгүй, өөрсдийн боломжоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Э.Анхбаяр/, санхүү албаны дарга /М.Солонго/ ахлах нягтлан бодогч /Ж.Нарантунгалаг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 484/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/238/НА-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан 2 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговорт, нийт 15,637,515.00 /арван таван сая зургаан зуун гучин долоон мянга таван зуун арван таван/ төгрөгийг төсвөөс олгосон, Шүүхийн шийдвэрийн дагуу харилцагч байгууллагад 61,333,223.00 /жаран нэгэн сая гурван зуун гучин гурван мянга хоёр зуун хорин гурван/ төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч буйцааж авахаар авлагын тооцоо үүсгэсэн, гэм буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ, 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", 103.4 "Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харуу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол төлүүлэх, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ аваагүй, гүйцэтгэлийг хянаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Санхүү албаны дарга /М.Солонго/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал /Э.Анхбаяр/-д даалгав


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-92.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 485/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/238/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст авлагын дансанд 40 байгууллага, хувь хүмүүсийн 396,466,900.00 / гурван зуун ерэн зургаан сая дөрвөн зуун жаран зургаан мянга өсөн зуун/ төгрөг, өглөг дансны үлдэгдэлд 81 харилцагчийн 5,347,580,447.00 /таван тэрбум гурван зуун дөчин долоон сая таван зуун наян мянга дөрвөн зуун дөчин долоон/ төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ахлах нягтлан бодогч /Ж.Нарантунгалаг/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал /Э.Анхбаяр/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ


Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан мэр шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харуу мэдэгдэнэ". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу явуулаагүй, худалдан авах гэрээний хэрэгжилтийг бүртгэж, гүйцэтгэлийг хянаагүй, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Худалдан авах ажиллагаа хариуцсан менежер /М.Нямсүрэн/, Санхүү албаны дарга /М.Солонго/ нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын хөрөнгөтөг төв эмнэлгийн захирал /Э.Анхбаяр/-д даалгав.



АНАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЦОЛТ
Н.ДЭЛГЭРМАА

АЛБАН ШААРДАГА ӨРСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭИ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ